



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Баянтоорой багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/135/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
	Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Аудитор: П. Ганцолмон
	Утас: 70157405 Цахим хаяг: uliastaivanaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа.....	14
4.3 Албан шаардлага.....	14
4.4 Зөвлөмж.....	13
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 122
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогт сумын Баянтоорой багийн Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цогт сумын Баянтоорой багийн Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жолоочийн тооцооны хуудсыг журмын дагуу хөтлөөгүй, санхүүгийн өмнөх оны авлагыг барагдуулаагүй, төсвийн хэмнэлтийг горимыг мөрдөж ажиллаагүй нийт 8.8 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль Төсвийн тухай хууль, Засгийн газрын хэмнэлтийн тогтоол, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07000399

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,783,289.64	30,810,886.18
33	АВЛАГА	6,575,403.44	6,318,085.98
33500	Бусад авлага	6,575,403.44	6,318,085.98
33510	Байгууллагаас авах авлага	6,575,403.44	6,318,085.98
35	БАРАА МАТЕРИАЛ	21,207,886.20	24,492,800.20
35100	Түүхий эд материал	18,200.00	193,500.00
35130	Эм боох материал	18,200.00	193,500.00
35400	Хангамжийн материал	21,189,686.20	24,299,300.20
35410	Бичиг хэргийн материал	252,500.00	151,500.00
35420	Аж ахуйн материал	8,041,000.00	8,041,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,135,800.00	2,120,000.00
35450	Барилгын засварын материал	57,000.00	57,000.00
35460	Хүнсний материал	0.00	4,226,414.00
35470	Бусад хангамжийн материал	9,703,386.20	9,703,386.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	196,983,273.86	193,437,588.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	196,983,273.86	193,437,588.33
39200	Биет хөрөнгө	188,683,273.86	185,437,588.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	175,847,154.03	175,847,154.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(8,347,885.40)	(10,873,894.52)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	18,626,736.00	21,820,736.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,709,047.84)	(12,053,126.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,520,582.95	34,520,582.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,118,565.88)	(24,688,163.73)
39217	Ном	864,300.00	864,300.00
39300	Биет бус хөрөнгө	8,300,000.00	8,000,000.00
39301	Програм хангамж	512,000.00	512,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(212,000.00)	(512,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,000,000.00	8,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	224,766,563.50	224,248,474.51
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	224,766,563.50	224,248,474.51
51	Засгийн газрын хувь оролцоо	224,766,563.50	224,248,474.51
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	40,073,788.35	40,073,788.35
51200	Хуримтлагдсан үр дүн	(2,299,907.51)	(2,817,996.50)
51210	Өмнөх үеийн үр дүн	7,358,495.98	(2,299,907.51)
51220	Тайлант үеийн үр дүн	(9,658,403.49)	(518,088.99)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	186,992,682.66	186,992,682.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	224,766,563.50	224,248,474.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/Төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	241,210,256.00	221,944,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,248,500.00	209,369,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,248,500.00	3,194,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,248,500.00	3,194,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,248,500.00	3,194,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	206,175,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	235,961,756.00	218,750,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	220,639,400.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	220,639,400.00	206,175,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,685,656.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,685,656.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,636,700.00	12,575,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,636,700.00	12,575,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	250,868,659.49	222,462,588.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	250,868,659.49	222,462,588.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	223,305,689.11	216,103,044.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,665,034.62	161,332,872.00
210101	Үндсэн цалин	134,927,618.62	136,418,372.00
210104	Урамшуулал	12,395,166.00	11,634,102.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,342,250.00	13,280,398.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,263,893.32	20,768,738.04
210201	Тэтгэврийн даатгал	15,279,845.32	14,558,054.80
210202	Тэтгэмжийн даатгал	132,644.00	1,285,736.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,293,608.00	1,337,203.48
210204	Ажилгүйдлийн даатгал	323,529.00	332,336.17
210205	Эрүүл мэндийн даатгал	3,234,267.00	3,255,406.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,434,347.00	13,389,537.00
210301	Гэрэл, цахилгаан	301,547.00	649,737.00
210302	Түлш, халаалт	12,132,800.00	12,739,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,457,200.00	3,614,676.00
210401	Бичиг хэрэг	819,500.00	287,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,747,500.00	2,399,976.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,000.00	193,300.00
210404	Ном, хэвлэл	129,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	220,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	521,200.00	638,100.00
2105	Нормативт зардал	13,408,537.20	7,777,736.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	174,300.00	353,200.00
210502	Хоол, хүнс	12,434,237.20	7,424,536.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	180,000.00	439,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	180,000.00	240,000.00
210604	Урсгал засвар	-	199,800.00

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	384,000.00	342,000.00
210702	Дотоод албан томилолт	384,000.00	342,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	416,000.00	923,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	275,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,096,676.97	7,514,685.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	375,000.00	775,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,721,676.97	6,739,685.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,562,970.38	6,359,544.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,885,656.00	1,200,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,685,656.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,953.00	1,463.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,953.00	1,463.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,673,361.38	5,158,081.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,673,361.38	5,158,081.44
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(9,658,403.49)	(518,088.99)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(9,658,403.49)	(518,088.99)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	40,073,788.35	186,992,682.66	7,358,495.98	234,424,966.99
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	40,073,788.35	186,992,682.66	7,358,495.98	234,424,966.99
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(9,658,403.49)	(9,658,403.49)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	40,073,788.35	186,992,682.66	(2,299,907.51)	224,766,563.50
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	40,073,788.35	186,992,682.66	(2,299,907.51)	224,766,563.50
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	40,073,788.35	186,992,682.66	(2,299,907.51)	224,766,563.50
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(518,088.99)	(518,088.99)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	40,073,788.35	186,992,682.66	(2,817,996.50)	224,248,474.51

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	235,961,756.00	218,750,500.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	235,961,756.00	218,750,500.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	220,639,400.00	206,175,500.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	220,639,400.00	206,175,500.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,685,656.00	0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,685,656.00	0	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,636,700.00	12,575,000.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,636,700.00	12,575,000.00	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	235,961,756.00	218,750,500.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,961,756.00	218,750,500.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	208,398,785.62	212,390,955.56	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,881,494.62	161,332,872.00	
210101	Үндсэн цалин	135,144,078.62	136,418,372.00	
210104	Урамшуулал	12,395,166.00	11,634,102.00	
210105	Гэрээт ажлын хөлс	14,342,250.00	13,280,398.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,241,044.00	20,934,920.56	
210201	Тэтгэврийн даатгал	15,256,996.00	14,724,237.32	
210202	Тэтгэмжийн даатгал	132,644.00	1,285,736.91	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,293,608.00	1,337,203.48	
210204	Ажилгүйдлийн даатгал	323,529.00	332,336.17	
210205	Эрүүл мэндийн даатгал	3,234,267.00	3,255,406.68	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,632,747.00	12,373,737.00	
210301	Гэрэл, цахилгаан	649,547.00	649,737.00	
210302	Түлш, халаалт	10,983,200.00	11,724,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	3,759,500.00	3,513,676.00	
210401	Бичиг хэрэг	750,000.00	186,300.00	
210402	Тээвэр, шатахуун	2,399,500.00	2,399,976.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,000.00	193,300.00	
210404	Ном, хэвлэл	120,000.00	0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	220,000.00	96,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,000.00	638,100.00	
2105	Нормативт зардал	9,593,500.00	11,755,950.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	162,500.00	548,500.00	
210502	Хоол, хүнс	8,431,000.00	11,207,450.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	180,000.00	439,800.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	180,000.00	240,000.00	
210604	Урсгал засвар	0	199,800.00	
2107	Томилолт, зочны зардал	384,000.00	342,000.00	
210702	Дотоод албан томилолт	384,000.00	342,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	416,000.00	923,000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	275,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	648,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	0	

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	310,500.00	775,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	310,500.00	775,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,562,970.38	6,359,544.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,885,656.00	1,200,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,685,656.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,953.00	1,463.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,953.00	1,463.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,673,361.38	5,158,081.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,673,361.38	5,158,081.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	218,750,500.00	213,590,955.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	218,750,500.00	213,590,955.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	217,550,500.00	212,390,955.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,699,900.00	161,332,872.00
210101	Үндсэн цалин	139,258,900.00	136,418,372.00
210104	Урамшуулал	11,969,000.00	11,634,102.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,472,000.00	13,280,398.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,374,900.00	20,934,920.56
210201	Тэтгэврийн даатгал	15,513,900.00	14,724,237.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,715,000.00	1,285,736.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,372,000.00	1,337,203.48
210204	Ажилгүйдлийн даатгал	342,000.00	332,336.17
210205	Эрүүл мэндийн даатгал	3,432,000.00	3,255,406.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,375,000.00	12,373,737.00
210301	Гэрэл, цахилгаан	650,000.00	649,737.00
210302	Түлш, халаалт	11,725,000.00	11,724,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,663,500.00	3,513,676.00
210401	Бичиг хэрэг	177,500.00	186,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,400,000.00	2,399,976.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	350,000.00	193,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	640,000.00	638,100.00
2105	Нормативт зардал	11,764,200.00	11,755,950.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	550,000.00	548,500.00
210502	Хоол, хүнс	11,214,200.00	11,207,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	440,000.00	439,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240,000.00	240,000.00
210604	Урсгал засвар	200,000.00	199,800.00
2107	Томилолт, зочны зардал	350,000.00	342,000.00
210702	Дотоод албан томилолт	350,000.00	342,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,108,000.00	923,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	460,000.00	275,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	775,000.00	775,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	775,000.00	775,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,200,000.00	1,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	1,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	218,750,500.00	213,590,955.56
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	206,175,500.00	201,017,418.56
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	206,175,500.00	201,017,418.56
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,575,000.00	12,573,537.00
320001	Орон нутгийн төсвөөс	12,575,000.00	12,573,537.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цогт сумын Баянтоорой багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Улиастай ван аудит” ХХК-ийн аудитор П.Ганцолмон гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Цогт сумын Баянтоорой багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус цэцэрлэг нь хичээлийн жилд хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, хоцрогдолгүй сургах, багшийн хөгжлийг хангах боломжийг бүрдүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчныг бүрдүүлж ажиллах зорилго тавьсан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цогт сумын Баянтоорой багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

Аудитын код: ГАА-2022/135/-НА-СТА-ТШЗ

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 209.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 222.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цогт сумын Баянтоорой багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.2 хувиар буюу 0.5 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 24.5 сая төгрөг болж 3.3 сая төгрөгөөр өссөн нь хүнсний материал, түлш шатах тослох материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 28.2 сая төгрөгийн, 0.4 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч үйл ажиллагаандаа 25.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 241.6 сая төгрөг болж 3.2 сая төгрөгөөр өссөн нь 3.2 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 224.2 сая төгрөг 0.5 болж сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 7.9 хувиар буюу 19.2 сая төгрөгөөр буурсан нь төсвөөс авсан санхүүжилт буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -0.5 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аудитын код: ГАА-2022/135/-НА-СТА-ТШЗ

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 296.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 77.4 сая төгрөгөөр бууруулж, 218.7 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 218.7 сая төгрөгийн төсөв баталснаас 206.2 сая төгрөгийг улсын төсвөөс 12.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 206.2 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 12.5 сая төгрөг нийт 218.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 213.5 сая төгрөгийг зарцуулж 5.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 213.5 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 3.4 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 1.4 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.20 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний зардлыг 0.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлан онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл 155.4 сая төгрөгийн 27 мэдээллээс санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг

Аудитын код: ГАА-2022/135/-НА-СТА-ТШЗ

мэдээлээгүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Худалдан авалтын 0.5 сая төгрөгийн и баримтыг цахимд шивүүлээгүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 13.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээс 13.0 сая төгрөгийн албан шаардлага биелүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан зөрчил байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй.

4.3 Албан шаардлага

- Жолоочийн тооцооны хуудсыг журмын дагуу хөтлөөгүй, тооцоо бодоогүй 2.7 сая төгрөгийн шатахууныг олгосон нь: нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.
- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны "төсвийн хэмнэлтийн талаар авах

зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.1-д "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

- Санхүүгийн тайланд он дамнасан 6.1 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Худалдан авалтын 0.5 сая төгрөгийн и баримтыг цахимд шивүүлээгүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 1алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 8 мэдээлэл, хугацаа болоогүй 2, мэдээллээгүй 1 мэдээлэл байна. 2021 оны 155.4 сая төгрөгийн 19 мэдээллийг ил тод байршуулахаас 155.4 сая төгрөгийн 19 мэдээллийг хугацаа хоцроон ил тод бүрэн байршуулсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын код: ГАА-2022/135/-НА-СТА-ТШЗ

4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Цогт сумын Баянтоорой багийн хүүхдийн цэцэрлэг	4	9.4	0	0	0	0	5	9.4	0	0